

## ДОТООД МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙГ ЭЗЭМШИГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. **Зорилго.** Энэхүү Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн үйл ажиллагааны журам (“Журам”)–ын зорилго нь Компанийн дотоод мэдээлэлд тооцогдох мэдээллийн агуулга, жагсаалтыг тодорхойлох, түүний эзэмшигчийг тогтоох, дотоод мэдээлэл эзэмшигчийн үүрэг, тэдгээрт хориглох үйл ажиллагаа болон дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тогтооход оршино.
- 1.2. **Хамрах хүрээ.** Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийн гишүүд, түүний нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч энэхүү Журмыг дагаж мөрдөнө.  

Энэхүү Журмыг аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр танилцуулж болох ба Компанийн цахим хуудаст байршуулж болно.
- 1.3. **Хяналт, нэмэлт өөрчлөлт.** Компанийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ–ийн нарийн бичгийн дарга 3 жил тутамд энэхүү Журмыг хянаж шаардлагатай бол түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ–д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.
- 1.4. **Журмын нөхцөл.** Энэхүү Журам болон Компанийн Дүрэм (“Дүрэм”)–ийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд Дүрэм давуу хүчинтэй байх ба энэ Журам нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зүйл, хэсэг, заалт давуу хүчинтэй байна. Энэ Журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Дүрэм, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам болон бусад холбогдох эрх зүйн актад зааснаар шийдвэрлэнэ.
- 1.5. **Нэр томъёоны тодорхойлолт**
  - 1.5.1. **Дотоод мэдээлэл** гэж Компанийн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх нийтийн хүртээл болоогүй, энэ Журмын 4-р зүйлд заасан агуулга бүхий мэдээллийг хэлнэ.
  - 1.5.2. **Дотоод мэдээлэл эзэмшигч** гэж дараах этгээдийг ойлгоно:
    - (i) Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд;
    - (ii) Компанийн толгой, охин, хараат компанийн эрх бүхий албан тушаалтан;
    - (iii) Компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмшигч;
    - (iv) Өөрийн албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон аль нэг үнэт цаас гаргагчтай холбоотой дотоод мэдээллийг шууд болон шууд бусаар олж авах боломжтой, эсхүл олж авсан Санхүүгийн

Зохицуулах Хороо, хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдийн ажилтан, тэдгээрийн холбогдох этгээд;

- (v) Компанийн хараат бус зөвлөхүүд болох хуульч, аудитор, үнэлгээчин, бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан;
- (vi) Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаа эзэмшигчдийн өмч болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх аливаа гэрээ байгуулсан, эсхүл гэрээ байгуулахаар завдаж буй этгээд, тэдгээр нь хуулийн этгээд бол түүний эрх бүхий албан тушаалтан;
- (vii) Гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд болон тэдгээрийн холбогдох этгээд;
- (viii) Дээрх 1.5.2(i)-(vi)(v)-д заасан үүрэгт албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа этгээд; болон
- (ix) Дээрх 1.5.2(i)-(vii)-д заасан дотоод мэдээлэл эзэмшигчдийн холбогдох этгээд.

1.5.3. **Нийтийн хүртээл болгох** гэж Компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ Журамд заасан дотоод мэдээллийг Компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудас, Санхүүгийн Зохицуулах Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг хэлнэ.

1.5.4. **Нийтийн хүртээл болохоос өмнө** гэдгийг Компани нь энэ Журмын 1.5.3-д заасан хэлбэрээр энэ Журмын 4-р зүйлд заасан дотоод мэдээлэл болон Компанийн Мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журмын **Error! Reference source not found.**-р зүйлд заасан мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө задруулахыг хэлнэ.

1.5.5. **Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч** гэж Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

1.5.6. **Холбогдох этгээд** гэдгийг дараах утгаар ойлгоно:

- (i) Хувь хүний тухайд тухайн хүний эхнэр, нөхөр, хүү, охин, өргөмөл хүү, өргөмөл охин буюу дагавар хүү, дагавар охин, хүргэн, бэр, ач, зээ, өөрийн болон түүний эхнэр/нөхрийн эцэг, эх, хойд эцэг, хойд эх, ах, эгч, дүү, эцэг нэгтэй буюу эх нэгтэй ах, эгч, дүү;
- (ii) Тухайн хүн эрх бүхий албан тушаалтнаар нь ажилладаг хуулийн этгээд;
- (iii) Тухайн этгээд ажил олгогч бол түүний ажилтан;
- (iv) Компани бол түүний толгой, хараат, охин, зэргэлдээ компани;

- (v) Санхүүгийн зохицуулах хорооноос “холбогдох этгээд” гэж тодорхойлсон бусад этгээд; болон
- (vi) Дээрх жагсаалтад заасан этгээд дангаар, эсхүл хамтдаа эзэмших саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг компани болон хуулийн этгээд.

1.5.7. **Хяналтын багцыг эзэмшигч** гэж Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны 1 буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшигчийг хэлнэ.

1.5.8. **Эрх бүхий албан тушаалтан** гэж ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-өөс эрх бүхий албан тушаалтнаар тооцсон бусад этгээдийг ойлгоно.

## 2. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧДИЙН ҮҮРЭГ

- 2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.
- 2.2. Нийтийн хүртээл болгохоос өмнө дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцохгүй байх.
- 2.3. Компанийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах.
- 2.4. Үнэт цаасны зах зээлийн талаар нийтэд мэдээлэх, холбогдох мэдээ мэдээллийг зохих хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулагчдад хүргэх.
- 2.5. Үнэт цаасны зах зээл дээр өөрт оногдсон ажил үүргийг ил тод, шударгаар гүйцэтгэх.
- 2.6. Байгууллага, иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх.
- 2.7. Дотоод мэдээллийн нууцыг хадгалах.

## 3. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧИД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулах.
- 3.2. Дотоод мэдээлэл эзэмшиж буй давуу талаа ашиглан ашиг олох зорилгоор өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах арилжаа хийх.
- 3.3. Дотоод мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах, мэдээлэх эсхүл гуравдагч этгээд дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх.
- 3.4. Дотоод мэдээлэл ашиглан үнэт цаас худалдаж авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, санал болгох.
- 3.5. Дотоод мэдээллийг эзэмшиж буй гуравдагч этгээд, өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад санал болгох, дотоод мэдээллийг дамжуулах, түүнчлэн дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх.
- 3.6. Энэ Журмын 1.5.1(vi)-д заасан этгээд дотоод мэдээлэл эзэмшиж байх хугацаандаа Компани болон Компанийн холбогдох этгээдийн үнэт цаасыг

худалдах, худалдан авах, түүнчлэн худалдан авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, ятгах, Компанитай хийж буй гэрээ хэлцлийн талаарх нийтийн хүртээл болоогүй байгаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах.

- 3.7. Хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох.
- 3.8. Энэ Журмын 4-р зүйлд заасан мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад дамжуулж, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэх.

#### 4. ДОТООД МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

- 4.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл (хувьцаа эзэмшигчийн овог, нэр, түүний өмчлөлд буй үнэт цаасны тоо, оршин суугаа хаяг).
- 4.2. үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, кастодиан банк дахь харилцагчийн үндсэн болон холболтын дансны мэдээлэл;
- 4.3. хэрэв хамаарах бол зохицуулалттай этгээдтэй байгуулсан харилцагчийн гэрээ, үнэт цаас эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд ажиллах бодлого, зорилго, үйл ажиллагаатай холбогдсон мэдээ баримт;
- 4.4. Компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооноос болон эрх бүхий байгууллагаас хийсэн шалгалтын тайлан, бусад материалд орсон нийтэд тараагдаагүй мэдээ баримт;
- 4.5. үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн, кастодианы үйл ажиллагаа явуулахад хэрэглэдэг тооцоолох машины санах байгууламжид агуулж байгаа мэдээ;
- 4.6. Компанийн үнэт цаасны арилжааны гүйлгээний мэдээ, дансны хуулга, харилцагчдын захиалгын сангийн мэдээлэл.
- 4.7. Компанийн өмчийн үнийн дүнгийн 25 болон түүнээс дээш хувийн өөрчлөлт.
- 4.8. Компанийн үйл ажиллагаа, бизнесийн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд.
- 4.9. Компанийн ашиг, алдагдал 25 болон түүнээс дээш хувиар өөрчлөгдөх.
- 4.10. Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувь болон түүнээс дээш хэмжээтэй тэнцэх хэмжээний өр, зээлийн өөрчлөлт.
- 4.11. Компани шинэ төрлийн үйл ажиллагаа эхлэх, үйл ажиллагааг зогсоох, үйл ажиллагаагаа худалдах.
- 4.12. Компанийн борлуулалтын орлогын 25-аас дээш хувийг эзлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл түдгэлзэх, хүчингүй болох, эсхүл хуульд заасан тохиолдолд худалдах, бэлэглэх зэрэг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх.
- 4.13. Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаа эзэмшигчдийн өмч болон Компанийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ батлагдах шатандаа явж буй эсхүл батлагдсан.
- 4.14. Санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд нь өмнөх жилүүдийн болон ирээдүйд төлөвлөсөн тооцооноос 25 хувиас илүү хэмжээгээр өөрчлөгдөх.

- 4.15. Компани нь өөрийн хөрөнгийн 15 хувь болон түүнээс дээш хэмжээний өр төлбөр, нийт хөрөнгийн 2 хувь болон түүнээс дээш хэмжээний хүү, алданги, торгууль төлөх үүрэг үүссэн тохиолдол.
- 4.16. Компани нь хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой чухал шийдвэр гарсан (томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө худалдаж авах, шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх).
- 4.17. Компани шинэ нээлт хийх, патент авах, ач холбогдол бүхий тусгай зөвшөөрөл эзэмших болсон.
- 4.18. Компанийн ирээдүйн үйл ажиллагаанд нөлөөлөх ач холбогдол бүхий арга хэмжээнүүд.
- 4.19. Компанийн удирдлагын бүтэц, хяналтад орсон өөрчлөлтүүд.
- 4.20. Компанийн гаргасан хувьцааны хяналтын багцыг аливаа этгээд дангаараа эсвэл нэгдмэл сонирхолтой этгээд хамтран худалдан авахаар тохиролцоонд хүрсэн, авсан.
- 4.21. Компанийн эрх бүхий албан тушаалтны өмчлөлд байгаа хувьцааны багад 5-аас дээш хувиар өөрчлөлт орсон.
- 4.22. Компанийн үйл ажиллагааг нь зогсоохоор нэхэмжлэл гаргасан, түүний эрх бүхий албан тушаалтан, хяналтын багц эзэмшигчдийн үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн.
- 4.23. Компани нь охин болон хараат компанитай болсон.
- 4.24. Компанийн охин болон хараат компанийн үйл ажиллагаа, хөрөнгө, эзэмшигчдийн өмч, өр, төлбөр, ашигт гарсан томоохон өөрчлөлтүүд.
- 4.25. Компани ногдол ашиг хуваарилах шийдвэр болон ногдол ашиг тараахтай холбогдсон бусад мэдээлэл.
- 4.26. Санхүүгийн Зохицуулах Хороо, хөрөнгийн бирж, бусад эрх бүхий байгууллагаас бүртгэлтэй үнэт цаасны арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах шийдвэр.
- 4.27. Компани нь аливаа хэлбэрээр өөрчлөн байгуулагдах тухай шийдвэр.
- 4.28. ТУЗ нь өрийг хувьцаагаар солих тухай шийдвэр.
- 4.29. Компанийг татан буулгах, үйл ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр.
- 4.30. Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомж, дүрэм журам, бусад эрх бүхий байгууллагын шийдвэр.

## **5. ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 5.1. Энэ Журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй болон хориглосон үйл ажиллагаа явуулсан дотоод мэдээлэл эзэмшигчид Үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээр бол төрийн эрх бүхий байгууллагад хандаж асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 5.2. Хэрэв хамаарах бол энэхүү Журмыг зөрчсөн этгээдэд дээр 5.1-т зааснаар хариуцлага хүлээлгэхээс гадна Компанийн дотоод журам болон (хэрэв бий бол) холбогдох гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.